



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/164

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Их эмчийн тангараг өргөх журам"-ыг нэгдүгээр, "Тангаргийн бичгийн загвар"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/, анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургуулийн захирал нарт даалгасугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/-т үүрэг болгосугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080546

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 07 сарын 25 ны өдрийн
А/ дугаар тушаалын 1 дүгээр
164 хавсралт



ИХ ЭМЧИЙН ТАНГАРАГ ӨРГӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургуулийг "Хүний их эмч", "Шүдний их эмч", "Уламжлалт анагаах ухааны их эмч" мэргэжлээр төгссөн их эмчийн тангараг өргөх ёслолын арга хэмжээ (цаашид "тангараг өргөх ёслол" гэх)-г энэхүү журмын дагуу зохион байгуулна.

1.2 Монгол Улсын анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургуулийг их эмчийн мэргэжлээр төгссөн эмч бүр тангараг өргөх ба тангараг өргөх ёслолын арга хэмжээг тухайн сургуулийн сургалтын алба зохион байгуулна.

1.3 Гадаад улсад анагаах ухааны боловсрол олгох сургуулийг их эмчийн мэргэжлээр төгссөн Монгол Улсын иргэний тангараг өргөх ёслолын арга хэмжээг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эрүүл мэндийн ажилтны хөгжлийн асуудал хариуцсан нэгж зохион байгуулна.

1.4 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага нь эрүүл мэндийн салбар, тухайн байгууллагын ой, түүхэн үйл явдал, эрүүл мэндийн ажилтны өдөр зэрэг тэмдэглэлт өдрийг сонгож, тангараг дээдлэн дуудах ёслолын арга хэмжээг зохион байгуулж болно.

1.5 Журмын 1.2, 1.3-т заасан тангараг өргөх ёслолын арга хэмжээнд эрүүл мэнд болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, бусад албаны төлөөлөгчийг оролцуулж болно.

Хоёр. Тангараг өргөх ёслолын үйл ажиллагаа

2.1 Тангараг өргөх ёслолын арга хэмжээг зохион байгуулах нэгж, алба нь тангараг өргөх газар, хугацаа /өдөр, цаг/-г байгууллагын дарга, захиралтай зөвшилцөн тогтоож, тангараг өргөх ёслолын арга хэмжээний бэлтгэлийг ханган, тангараг өргөх тухай тушаал, их эмчийн нэрсийн жагсаалт, тангаргийн бичгийн хэвлэмэл хуудас, нэрийн тэмдгийг урьдчилан бэлтгэнэ. Тангараг өргөх тухай тушаалыг байгууллагын дарга, захирал батална.

2.2 Тангараг өргөх их эмчид тангараг өргөх ёслолын арга хэмжээ болох газар, хугацааг урьдчилан мэдэгдэнэ.

2.3 Тангараг өргөх ёслолын арга хэмжээ болох өрөө, танхимыг ёслол төгөлдөр тусгайлан бэлтгэж, Монгол Улсын төрийн сүлд, далбааг хүндэтгэлтэйгээр байрлуулна.

2.4 Тангараг өргөх их эмч нь тогтоосон цагт тусгайлан бэлтгэсэн өрөө, танхимд эмчийн дүрэмт хувцастай хүрэлцэн ирж, Монгол Улсын төрийн сүлд рүү харан хүндэтгэлтэйгээр цэх зогсоно.

- 2.5 Тухайн байгууллагын дарга, захирлаас томилсон албан тушаалтан тангараг өргөх ёслолын арга хэмжээг удирдана.
- 2.6 Тангараг өргөх ёслолын арга хэмжээг удирдахаар томилогдсон албан тушаалтан арга хэмжээг нээж, төлөөлөгчдийг танилцуулсны дараа тангараг өргүүлэх тухай тушаал уншина.
- 2.7 Тангараг өргүүлэх тухай тушаал уншсаны дараа их эмч тангаргийг хамтаар буюу ганцаар өргөнө. Хамтаар өргөхөд тэргүүний төгсөгч их эмч "Эмч би, эмчийн ёс зүй, төрийн хуулийг чандлан сахиж, эрдэнэт хүний амь нас, эрүүл мэндийн төлөө эрдэм чадал, энэрэх сэтгэлээ харамгүй зориулахаа тангараглая, тангараглая, тангараглая" гэж тангаргийг бусдадаа дуулдахуйц тод дуугаар уншихад бусад их эмч дагаж хэлнэ.
- 2.8 Тангараг өргөж байх үед ёслолд оролцогчид босч хүндэтгэнэ.
- 2.9 Тангаргийг дуудаж дууссаны дараа тангараг өргөсөн их эмч бүр Монгол Улсын төрийн сүлдэнд ээлж дараатайгаар мэхийн ёсолж, зүүн өвдөг сөхрөн Монгол Улсын төрийн далбаанаас адис авна.
- 2.10 Монгол Улсын төрийн сүлдэнд мэхийн ёсолж, төрийн далбаанаас адис авсны дараа тангараг өргөсөн эмч бүр тангаргийн бичигт гарын үсэг зурна.
- 2.11 Ёслолын арга хэмжээнд ирсэн хүндэт төлөөлөгчид тангараг өргөсөн эмчид тангаргийн бичгийг нэрийн тэмдгийн хамт гардуулна.
- 2.12. Тангараг өргөх ёслолын арга хэмжээг удирдаж байгаа албан тушаалтан тангараг өргөсөн их эмч нарт баяр хүргэж, үг хэлсний дараа Монгол Улсын төрийн дууллыг эгшиглүүлснээр арга хэмжээ дуусгавар болно.

Гурав. Бусад

- 3.1 Тангаргийн бичиг нь 210 мм х 297 мм хэмжээтэй, цагаан дэвсгэртэй, нүүрэн талдаа Монгол Улсын төрийн сүлдтэй, түүний дор "Их эмчийн тангаргийн бичиг" гэсэн мөнгөлөг үсэгтэй, дотор тал нь мөнгөлөг алхан хээ хүрээтэй, Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Их эмчийн тангараг"-ийн бүрэн бичвэртэй байна.
- 3.2 Гарын үсэг зурсан тангаргийн бичгийг их эмч өөрөө хадгална.
- 3.3 Тангараг өргөх ёслолын арга хэмжээний дэс дарааллыг тодорхой тусгасан тэмдэглэл хөтлөх бөгөөд гэрэл зураг авч, дүрс бичлэг хийж болно.
- 3.4 Анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургуулийн сургалтын алба нь энэхүү журмын 3.3-д дурдсан тэмдэглэлд тангараг өргөсөн их эмчийн овог нэр, нас, хүйс, регистрийн дугаар, мэргэжил, иргэншил, тангараг өргөснийг баталгаажуулсан гарын үсэг бүхий мэдээллийг хүснэгтээр гаргаж хавсарган, тангараг өргөх ёслолын арга хэмжээг зохион байгуулсанаас хойш ажлын 10 хоногт багтаан Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлнэ.
- 3.5 Эрүүл мэндийн хөгжлийн төв нь журмын 1.3-т дурдсаны дагуу тангараг өргөх ёслолын арга хэмжээ зохион байгуулсан тэмдэглэлийг хөтөлж, тэмдэглэлд тангараг өргөсөн их эмчийн овог нэр, нас, хүйс, регистрийн дугаар, мэргэжил, иргэншил, тангараг өргөснийг баталгаажуулсан гарын үсэг бүхий мэдээллийг хүснэгтээр гаргаж, хавсаргана.
- 3.6 Эрүүл мэндийн хөгжлийн төв нь 3.3, 3.4, 3.5-д дурдсан тэмдэглэл, хавсралт мэдээллийг нэгтгэн холбогдох хууль, журмын дагуу архивын нэгж үүсгэн хадгална.

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 04 сарын 25-ны өдрийн
А/ дугаар тушаалын 2 дугаар
164 хавсралт



ТАНГАРГИЙН БИЧГИЙН ЗАГВАР

Нүүрэн тал



ИХ ЭМЧИЙН ТАНГАРГИЙН БИЧИГ

Дотор тал

ЭМЧ БИ,
ЭМЧИЙН ЁС ЗҮЙ, ТӨРИЙН ХУУЛИЙГ ЧАНДЛАН САХИЖ,
ЭРДЭНЭТ ХҮНИЙ АМЬ НАС, ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨЛӨӨ
ЭРДЭМ ЧАДАЛ, ЭНЭРЭХ СЭТГЭЛЭЭ ХАРАМГҮЙ ЗОРИУЛАХАА
ТАНГАРАГЛАЯ, ТАНГАРАГЛАЯ, ТАНГАРАГЛАЯ

...../мэргэжлийн чиглэл/

..... /овог/..... /нэр/

...../гарын үсэг/

Тангараг өргөсөн

..... оны дугаар сарын-ны өдөр

.....
/сургууль, байгууллагын нэр/